



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛС БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО ТОМИЛОГДСОН БҮРЭЛДЭХҮҮНЭЭРЭЭ
АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Тайлангбэлтгэсэн:

ААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг

Газрын дарга, тэргүүлэх
аудитор

Ч.Чүлтэмбат

Аудитын менежер

Ш.Мөнхбаяр

Аудитор

Ч.Гантулга
Г.Батмягмар
Н.Отгонцэцэг

2018 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал 7037-
3089, 7037-8142 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ:

Аймгийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр
Дархан-Уул аймаг

Товчилсон үгийн жагсаалт 3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй . . . 4-6

Бүлэг 1

- 1.1. Дархан хотын хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилт, хөтөлбөр зэргийг ханган биелүүлэхэд чиглэгдсэн байна.7
- 1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 129 ТАХ-нд 5,827.9 сая төгрөг баталжээ.....8
- 1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 салбарт 4.3 тэрбум төсөвт өртөг бүхий 7 ТАХ-ээ хийгджээ.....8-9
- 1.4. 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-д газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл хууль журмын дагуу олгогдсон байна.....9

Бүлэг 2

- 2.1. Худалдан авах ажиллагааны алба 2017 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллажээ.....10
- 2.2. Захиалагчаас ажлын даалгавар, материал ирээгүйгээс 4 ТАХ-ээ тендер шалгаруулалт хийгдээгүй байна.....11
- 2.3. Тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой 2 гомдол гарчээ..... 11-12
- 2.4. Үнэлгээний хороо томилогдсон бүрэлдэхүүнээрээ ажиллаагүй байна.....12-15
- 2.5. ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчилсөн зөрчил байхгүй байв.....15

Бүлэг 3

- 3.1 Гүйцэтгэгч компанитай байгуулсан ажил гэрээт хугацаандаа хэрэгжсэн байна.....16
- 3.2 Зарим төсөл арга хэмжээн дээр өмнөх аудитын зөвлөмж биелэгдээгүй байна.....15
- 3.3 Баталгаат засварын хугацаанд хэрэгжсэн ТАХ-ний эвдрэл гэмтлийг засуулах 17
- 3.4 ТАХ-ээ хэрэгжсэн хөрөнгийг бүртгэлд авах ИТХ-ын тогтоол тайлант онд гарахгүй байна.....17
- 3.5 ТАХ-ний хэрэгжилтэд техник хяналтыг гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулжээ..... 17-18

Дүгнэлт, зөвлөмж.....19

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|--|
| АЗДТГ | Аймгийн Засаг даргын тамгын газар |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үзүүлэлт |
| ХОХБТХ | Хөгжлийн оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| ТБОНӨХБҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |
| ИТХТ | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| УИХ | Улсын их хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ТАХ | Төлсөл арга хэмжээ |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ИШС | Инженерийн шугам сүлжээ |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| БСШУСС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөж тооцож үнэлсэн эсэх
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт санхүүжилт үр нөлөөтэй байсан эсэх

Хамарсан хүрээ:

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох байгууллага болон аймаг орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хүрээнд шалгалаа. Үүнд: Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан аймгийн ЗДТГ-ын “ХОХБТХэлтэс”, “Орон нутгийн өмчийн газар”, захиалагчийн техникийн хяналтыг хийсэн “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ, сумдын ЗДТГ, захиалагч болон тендерт шалгарч гэрээ байгуулсан гүйцэтгэгч, ашиглагч байгууллагууд хамрагдсан болно.

Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах зэргээр МУ-ын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний арга зүйг ашиглалаа.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Барилгын тухай хууль
- Дээрх хуулийг хөрөгжүүлэхтэй болбогдуулан гаргасан УИХ, ЗГ-ын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- ЗГ-ын 2015 оны 377 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан орон нутгийн төсвөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, төсвийн тодотголоор өөрчлөлт орсон төсөл, арга хэмжээний жагсаалтууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат удирдаж, аудитын менежер Ш.Мөнхбаяр үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ч.Гантулга, Г.Батмягмар, Н. Отгонцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 27-нд эхэлж, 04 дүгээр сарын 19-нд гүйцэтгэж, аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад хүргүүлээ.

Үндсэн мэдээлэл:

- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Дархан-Уул аймагт 62,557.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй он дамжин хэрэгжиж байгаа 5 төсөл, арга хэмжээг 11,590.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Дээрх арга хэмжээнүүдийн 83.1 хувийг барилга, 16.9 хувийг эрчим хүчний байгууллагад хуваарилжээ. Дээрх ТАХ-ээс 2017 онд хэрэгжиж дуусах 3 төсөл, арга хэмжээ байна.


Үүнээс хамгийн олон жил дамжин хэрэгжиж байгаа 2011 онд эхэлж баригдсан 21,443.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2200 хүний суудалтай Спортын цогцолбор барилга, 2012 онд эхэлсэн 12,271.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Малын удмын сангийн үндэсний цогцолбор барилга байна.

Аймгийн Засаг даргад 2017 онд хэрэгжүүлэхээр эрх нь шилжиж ирсэн 6 ТАХ-ээ иржээ. Үүнд:

1. Дархан сумын Од цогцолбор сургуулийн барилгын дээврийн засварын ажил 100.0 сая төгрөг,
2. ОИЦогцолбор сургуулийн “А” байрны дээврийн засварын ажил 70.0 сая,
3. 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугам, спорт заалны засварын ажил 50.0 сая,
4. 18 дугаар сургуулийн дулааны узель, ялтсан дулаан солилцуурын засварын ажил 40.0 сая,
5. , Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил 100.0 сая,
6. Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, нарклогийн тасгийн барилгын дээврийн засварын ажил 55.1 сая,

Бүлэг 1**Төсөл, арга хэмжээг холбогдох хуулиудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн байна.****НЭГ. Төсөл, арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөж, батлуулсан эсэх**

1.1 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг 2017 оны төсөвт тусгуулах санал нь Дархан хотыг 2021 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны зорилт, аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг ханган биелүүлэхэд чиглэгдсэн байна.



Дээрх графикаас харахад Дархан-Уул аймагт сүүлийн 3 жилийн байдлаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа нь бүтээн байгуулалтын ажил нэмэгдснийг харуулж байна.

1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хийгдэх ТАХ-ний санхүүжилтийн тодотголыг хүснэгтээр харуулбал:

сая. төг

| № | | Эхлэх дуусах хугацаа | Төсөв 2016.12.02 | | Тодотгол 2017.02.17 | | Тодотгол 2017.05.05 | | Тодотгол 2017.10.02 | | Тодотгол 2017.12.01 | |
|---|--------------|----------------------|------------------|----------|---------------------|----------|---------------------|----------|---------------------|----------|---------------------|----------|
| | | | төсөвт өртөг | 2017 онд | төсөвт өртөг | 2017 онд | төсөвт өртөг | 2017 онд | төсөвт өртөг | 2017 онд | төсөвт өртөг | 2017 онд |
| 1 | Шилжих ХО | 2017 | | | 2,523.2 | 1,219.5 | 2,533.3 | 1,159.5 | 2,451.9 | 1,147.9 | 2,114.3 | 1,135.3 |
| 2 | Шинээр эхлэх | 2017 | 8,633.5 | 2,008.9 | 12,412.9 | 3,734.2 | 12,393.2 | 4,308.1 | 12,832.3 | 4,546.9 | 7,617.7 | 4,692.6 |

| | | | | | | | | | | | | |
|--|-----|--|---------|---------|----------|---------|----------|---------|----------|---------|---------|---------|
| | ХО | | | | | | | | | | | |
| | Дүн | | 8,633.5 | 2,008.9 | 14,936.1 | 4,953.8 | 14,926.5 | 5,467.6 | 15,284.2 | 5,694.8 | 9,732.0 | 5,827.9 |

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 5/02 тоот тогтоолоор 2017 оны хөрөнгө оруулалтад 2,008.9 сая төгрөг баталжээ. Үүнээс хойш 4 удаагийн төсвийн тодотголоор өөрчлөлт оруулсан ба аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/05 тоот тогтоолоор төсвийн тодотгол хийн зардлын дээд хэмжээг 129 ТАХ-нд 5,827.9 сая төгрөгөөр баталсан байна. Үүний 93 хувьд нь барилга байгууламж, зам засвар, нийтийн орон сууцны барилгын дээвэр, зоорийн давхарын ИШС-ний засвар дэд бүтцийг сайжруулахаар төлөвлөсөн нь Дархан хотыг 2021 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны зорилт, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажилтай нийцсэн ажил болжээ.

1.3 Төсвийн тухай хуулийн 28.2-д ”Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу АЗДТГ-ын ХОХБТХ салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд нэгж байгууллагуудын боловсруулсан төсөл, арга хэмжээний саналын үр дүн, үр ашгийн тооцоог үндэслэн нэгтгэж нийт 8 салбарт 139.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 ТАХ-г 2017 онд хэрэгжүүлэхээр санал хүргүүлжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 4 салбарт нийт 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг тус онд санхүүжүүлэн гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 4 удаа тодотгон 3,819.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь тендерийн хэмнэлт, гүйцэтгэлийн зөрүүгээс бий болсон хөрөнгөөр нэмэгдсэн ТАХ-г санхүүжүүлэх болсон байна.

- Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 6 дугаар хуралдаанаар оны эхний давсан орлогоор аймгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нийт 4,953.8 сая төгрөгөөр тооцон шилжих хөрөнгө оруулалтын 36 арга хэмжээг 1,219.5 сая төгрөгөөр, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 46 төсөл, арга хэмжээг 3,734.3 төгрөгөөр санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан.
- Өмнөх хуралдаанаар төсвийн хөрөнгө оруулалтыг 4,953.8 сая төгрөгөөр батлагдснаас:
 - Шилжих хөрөнгө оруулалтын ОУ-ын чанартай төв авто замын доогуур нүхэн гарц гаргах ажлын зураг төсөл боловсруулах ажлын 50,0 сая, 16-н давхар

байрны урд талын авто замын гэрлэн дохио шинээр суурилуулах ажлын 10.0 сая, Дархан сумын 6-р багт Эрүүл мэндийн төв шинээр барих ажлын 20.0 сая, Дархан сумын 9, 10-р багийн ус зайлуулах шугам, хоолойн зураг төсөв боловсруулах ажлын 10.0 сая нийт 100,0 сая төгрөгийн ажлыг зогсоохоор төлөвлөсөн бөгөөд төсвийн орлогыг 513.8 сая төгрөгөөг нэмж, төсвийн хөрөнгө оруулалтыг 5,467.6 төгрөг байхаар тооцож баталсан байна.

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 5,467.2 сая төгрөгөөр өмнөх хуралдаанаар баталсан бөгөөд уг хөрөнгө оруулалтыг татварын орлогоор 133.0 сая, тендерийн хэмнэлт 0.8 сая, гүйцэтгэлийн зөрүү 18.1 сая, байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэмнэлт болох 75.8 сая, нийт 227.2 сая төгрөгөөр 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр нэмэгдүүлж төсвийн хөрөнгө оруулалтыг 5,694.8 сая төгрөг байхаар тооцсон байна.
- Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанаар төсвийн хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлт, гүйцэтгэлийн санхүүжилтийн зөрүү 18.8 сая, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээрх орлогын боломжит эх үүсвэрээр 133.0 сая, нийт 151.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тооцон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 5,827.9 сая төгрөг байхаар тооцсон байна.

1.4 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл хууль, журмын дагуу олгогджээ.

БҮЛЭГ 2**Үнэлгээний хороо томилогдсон бүрэлдэхүүнээр ажиллахгүй байна.****ХОЁР. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх**

2.1 Дархан-Уул аймагт 2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих нийт 4,313.2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргад эрх нь шилжиж ирсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 4098,1 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 215,1 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар хийжээ.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтыг хүснэгтээр харуулбал:

/Сая төгрөгөөр/


| д.д | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв | Гэрээний дүн | Эрх шилжсэн | ХАА |
|------------|---|------------------|----------------|-------------|-----|
| 1 | Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологиын тасгийн барилгын дээврийн засвар | 55.1 | 53.0 | ЭМС | ХА |
| 2 | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Дулааны станцаас дулаан хувиарлах төв хүртлэх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил /түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/ | 3898.1 | 3888.0 | ЭХС | НТШ |
| 3 | Сургуулийн дээвэр засвар /Дархан - Уул, Дархан сум, "Од" цогцолбор сургууль/ | 100.0 | 85.2 | БСШУСС | НТШ |
| 4 | Сургуулийн барилгын дулааны узель, ялтсан дулаан солилцуурын засвар /18 дугаар сургууль/ | 40.0 | 39.3 | БСШУСС | ХА |
| 5 | Дархан - Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугам, спорт заалны засвар | 50.0 | 49.5 | БСШУСС | ХА |
| 6 | Дархан - Уул аймгийн Дархан сумын Оюуны ирээдүй цогцолбор сургуулын "А" байрны дээврийн засвар | 70.0 | 67.9 | БСШУСС | ХА |
| 7 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Шарынголсум 2-р цэцэрлэг/ | 100.0 | 98.4 | БСШУСС | НТШ |
| ДҮН | | 4,313.2 | 4,281.3 | | |

2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих нийт 3,157.6 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 13,5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 53,8 хувийг харьцуулалтын аргаар, 25 хувийг шууд гэрээний аргаар тус тус хийсэн байна.

Харин захиалагчаас ажлын даалгавар, материал ирээгүйгээс 7,7 хувь буюу 4 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт хийгдээгүй байна. Үүнд:

1. Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн хүрээнд бохир усны шугам хоолой шинэчлэх
2. Аймгийн урт хугацааны бодлого боловсруулах / 2017-2030 он /
3. Дархан сумын 15-р баг цэвэр усны шугамын шинэчлэлт
4. АЗДТГ-ын нэг давхарын засварын ажил

Орон нутгийн төсвөөс санхүүжих төсөл



2.3 Аймгийн Засаг даргын захирамжаар тендерийг хуулийн дагуу явуулах үүрэг бүхий үнэлгээний хороог ажлын онцлог, салбарын чиглэл, АЗ сертификат бүхий иргэдээс сонгон 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүний тоог олон болгож, нэг хороонд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөлөөс гадна, хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөллийг оролцуулах замаар ХАА-г зохион байгуулжээ.

Мөн нийт төсөл арга хэмжээний 95 хувийг вэб хуудсанд байрлуулж мэдээллийг цахим системээр нийтэд дамжуулж байгаа нь сайшаалтай байна.

Сангийн яамны Хууль, эрх зүйн газарт худалдан авах ажиллагааны талаар 2 гомдол ирсэн байна. Үүнд:

- “Дархан секьюрити” ХХК-ний зүгээс Дархан сумын 13, 14, 16 дугаар багийг хяналтын камерын системд шилжүүлэх ажил, ДА-ОНӨГ/2017-36 дугаар бүхий тендерийн сонгон шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдаагүй.


- “Хас жинст” ХХК-ний зүгээс Дархан сумын 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугамын засвар, спорт заалны засварын ажил, БСШУСЯ/2017-04008 дугаар бүхий тендерийн сонгон шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдаагүй.

Сангийн яам дээрх гомдлуудыг хянан үзээд Үнэлгээний хорооны гаргасан шийдвэр үндэслэлтэй гэж үзжээ.

2.4 Үнэлгээний хорооны гишүүдийн иргэдийн төлөөллийн ирц хангалтгүй байна. Тухайлбал Дархан сумын иргэн Б. Мөнгөн 3 тендер, С. Эрдэнэбат 2 тендер, С.Сүнчин 2 тендер, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч П. Юра 2 удаа тендерийн сонгон шалгаруулалтанд тус тус оролцоогүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг бөглөөгүй байна.

Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг дараах байдалтай гаргаж, баталгаажуулжээ.

Үнэлгээний хорооны зөвшөөрлийн мэдүүлэг



Энэ нь Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 2.4-т заасан **“Үнэлгээний хорооны гишүүд хуульд заасан шаардлагыг хангаж байгаа болон тендерийн үнэлгээний талаарх мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллагын нууцыг задруулахгүй байх тухайгаа Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гаргаж, баталгаажуулна”** гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа дараах алдаа, зөрчлийг гаргажээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих АЗДТГ азарт “суудлын авто машин худалдан авах”, “туулах чадвар сайтай авто машин худалдан авах” ТАХ-ний тендер сонгон шалгаруулалтуудыг явуулахдаа вэб сайтад байршуулаагүй нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т **“Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер**

шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ”. 52.1.12-т “Худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох” гэсэн заалт.

Дархан сумын 2-р багт 12, 13-р багт 6 ширхэг лэд гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын Үнэлгээний хорооны 5 гишүүнээс 2 гишүүн ирээгүй, 1 гишүүн хурлын шийдвэрт гарын үсэг зураагүй байна. Энэ нь Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 4.2-т заасан **“Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно”** гэсэн заалт.

Нийт төсөл, арга хэмжээний 78.6 хувь нь тендер шалгаруулалтыг нээсэн өдрөөс хойш, ойролцоогоор 11 хоногийн дараа үнэлгээний хороо хуралджээ. Дийлэнх тендерийг нээсэн өдрийн нээлтийн тэмдэглэлд Үнэлгээний хорооны гишүүдийн ирц бүрэн бус, гарын үсэг зурагдаагүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 4.3-т заасан **“Тендер шалгаруулалтыг нээсэн өдөр үнэлгээний хороо эхний хуралдааныг хийх бөгөөд хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээг хийнэ”** гэсэн заалт.

“Шилэн эмнэлэг төсөл”-ийн 2 дугаар шат, “Туулах чадвар сайтай авто машин худалдан авах” тендерийн материалуудад Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр байхгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47,7-д **“Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна”** гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Мөн нийт тендер оролцогч байгууллагын материал бүрдүүлэлт болон шалгуур үзүүлэлтүүдэд дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Биржийн таван замын уулзварын үерийн ус зайлуулах хоолойн засвар шинэчлэлт төсөл, арга хэмжээнд шалгуур үзүүлэлтэнд 2015, 2016 оны санхүүгийн тайлан /Аудитаар баталгаажуулсан байх/ гэж заасан байхад тендерт шалгарсан “Эвт-Уул” ХХК нь 2016 оны санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулаагүй.
- Дархан сум 25-р хорооллын доторх авто замыг хатуу хучилттай болгох эхний үе шатны ажлын тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд **“Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг нотлох баримт ирүүлнэ”** гэж заасан байхад шалгарсан “Дархан АЗЗА” ХХК нь тус баримтыг бүрдүүлээгүй.

- 2017 оны 03 дугаар сарын 17-нд “Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологиын тасгийн барилгын дээврийн засвар”-ын тендерт оролцсон “Зууны цамхаг” ХХК-ыг борлуулалтын орлого 2016 онд 12.3 сая төгрөг байгаа боловч 2016 онд 24.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь эргэлзээтэй, дан хувийн байгууллага, хувь хүнтэй гэрээ хийсэн, мэргэжилтэй ажилчдын хөдөлмөрийн гэрээ байхгүй гэсэн шалтгаанаар хассан байна. Харин 2017 оны 05 дугаар сарын 04-нд болсон Дархан сумын 4, 9, 12, 14-р багуудын НОС-ны орцны хаалгыг шинэчлэх “Миний гэр-Манай байр” хөтөлбөрийн тендерт шалгаруулалтанд дээрх үзүүлэлтийг тооцоогүй тус компанийг шалгаруулсан байна.
- Дархан сумын 2-р багт 12 ширхэг, 13-р багт 6 ширхэг лэд гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажилд шалгарсан “Ледсити ХХК”-ийн бүрдүүлсэн материалд шүүхийн лавлагаа нь тамга тэмдэггүй.
- Олон төрлийн үйлдэлт авто машин худалдан авах /НААҮГазарт/ тендерт сонгон шалгаруулах үнэлгээний хорооны шалгаруулалт 2017 оны 12 дугаар сарын 24-нд хуралдсан боловч сонин болон сайтад 2017 оны 02 сарын 23-нд тавигдсан нь зөрүүтэй байна.
- АЗДТГ-ын байрны өргөтгөлийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд *“Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлэх”* гэж заасан байсныг тус тендерт шалгарсан “Топ Универсал констракшн” ХХКнь ирүүлээгүй.
- Шарын гол сумын 2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл ажлыг гүйцэтгэхээр “Дархан трейд ХХК” шалгарсан. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд *“Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг нотлон ирүүлнэ”* гэж заасан байдаг. Гэтэлүл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ барьцаанд байгаа эсэх лавлагаагүй, үнэлгээний эрх бүхий байгууллагаар үнэлэгдээгүй, банкнаас зээл олгох баримтгүй, банкинд 83.6 сая төгрөгийн хэвийн төлөлттэй зээлийн үлдэгдэлтэй зэрэг нь тус хөрөнгийг түргэн хөрвөх чадвартай хөрөнгө гэж үзэхэд хангалтгүй байна.

2.5 Дархан-Уул аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчилсөн зөрчил гараагүй байна.

БҮЛЭГ 3**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил 98 хувьтай хийгдсэн байна.****ГУРАВ. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт санхүүжилт үр нөлөөтэй байсан эсэх**

3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн ТАХ-ний хувьд гүйцэтгэгч компанитай байгуулсан ажил гэрээт хугацаандаа хэрэгжиж, санхүүжилтээ бүрэн авчээ.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх 129 төсөл, арга хэмжээнээс гэрээт хугацаандаа дуусаагүй он дамжин хийгдэх болсон “Шүтэн-Уул” ХХК-ний “Үйлдвэрлэлийн шаардлагад нийцэх ажиллах хүчнийг бэлтгэх төсөл”, “Дархан иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл” НҮТББ-ын “Аялал, амралтын цогцолбор байгуулах төсөл”, “Дархан сити электрон” ХХК-ний цуврал нэвтрүүлэг бэлтгэх төсөл, иргэн П.Ганбатын “Амралт чөлөөт цагийн сүүдрэвч төсөл”-үүдийн 27.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Мөн ажил нь дууссан боловч 58.7 сая төгрөг санхүүжилт дутуу олгогдсон 26 төсөл, арга хэмжээ байна.

3.2 Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газраас “Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар **“Шууд гэрээгээр хийгдсэн ажлын хувьд нэг ижил зориулалтай, байршил ойрхон, нэг компани гүйцэтгэсэн, ажлын төсөвт өртгийг хэт жижиглэн олон болгож 3.0-10 сая төгрөгт багтаасан байна”** гэсэн зөвлөмжийг биелүүлж ажилласан боловч зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дээрх алдааг давтагдан гарсан байна. Тухайлбал:

“Сонголон хайрхан” ХХК-нд 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Дархан сумын 6-р багийн тохижилтын ажил, “Шүүдэр гранд” ХХК, “Дархан ээж шүтээн” ХХК-уудад тус бүр 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сагсан бөмбөгийн талбай барих ажлыг тус бүр 2 болгон хувааж, 10,0 сая төгрөгт багтаажээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5-д **“Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлс хийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”** гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГазарт 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй KIA үйлдвэрийн портер машиныг шууд гэрээгээр худалдан авчээ.

3.3 Дархан сумын 13,14,16-р багт Хяналтын камерийн системд шилжүүлэх ажлыг “Локус монгол” ХХК хийж гүйцэтгэсэн. Энэ төсөл, арга хэмжээ нь иргэдийн аюулгүй байдлыг хангасан хулгай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн ажил болсон ч Дархан сумын 16-р багт 2 камер, 14-р багт 1 камер нийт 1,050.0 мянган төгрөгийн өртөгтэй 3 камер эвдэрсэн байна.

“ОДНД” ХХК нь 1,433.7 мянган төгрөгийн магадлашгүй ажлын зардлаар хийсэн Дархан сумын 6, 7, 8-р багийн авто замын шинэчлэлтийг чанаргүй хийсэн.

"Дархан орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГазарт KIA үйлдвэрийн портер машин 12.8 сая төгрөгөөр шууд гэрээгээр авч, 2017 оны 4 сард Шарын гол суманд албан ажилаа гүйцэтгэж яваад осол гарган эвдрэл гаргасныг одоо болтол засуулаагүй.

Дээрх алдаа зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээд байна.

3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг хугацаандаа гүйцэтгэсэн ч түүнийг бүртгэлд авах аймгийн ИТХ-ын тогтоол дараа оны 3 дугаар сард гарч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “жинхэнэ хэрэгжилт”-ийн зарчимтай нийцэхгүй байна. Тухайлбал:

“Аймгийн прокурорын газар”, “Авто тээврийн төв”-д тус бүр 7.5 сая төгрөгийн өртөгтэй “Sonata-6” маркын авто машин, аймгийн ЗДТГ-ын 98.1 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламж, тоног төхөөрөмж, Байгаль орчин аялал жуулчлалын газрын 25.9 сая төгрөгийн өртөгтэй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Биеийн тамир спортын газрын 83.8 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 25 тоот тогтоолоор бүртгэлд авчээ.

3.5 “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ орон нутагт эрх шилжсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд техник хяналтыг гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллажээ. Түүнчлэн гүйцэтгэгч байгууллага тус бүртэй техник хяналтын гэрээ байгуулж, хөрөнгө оруулалтын ажлыг дүгнэсэн байв.

Аудитаар аймаг, сумын төвд хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн, хяналтын инженерүүдтэй хамтран газар дээр нь шалгахад захиалагчийн хяналт сайн хийгдсэн байлаа.

“Дархан хот, байгуулалт барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГазар 2017 онд захиалагчийн техникийн хяналтыг хийж, баталгаажуулах явцад төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагуудын хийгээгүй ажлыг хасаж, төсвийн хөрөнгийн үр ашигтай байдлыг ханган 8.2 сая төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлсэн байна.

ДҮГНЭЛТ:

4.1 Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг өгч байна.

1. Орон нутгийн хөрөнгөөр 2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялджээ.
2. Аймгийн Засаг даргад эрх шилжсэн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээ Дархан-Уул аймгийг хөгжүүлэх, иргэдийн сэтгэлд нийцсэн, нийгмийн хүлээгдэж буй ажилд төлөвлөгдөж, үр дүнтэй хэрэгжсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

4.2 Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга Г. Эрдэнэбатад зөвлөж байна.

- Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд тусгах ИТХ-ын тогтоолын шийдвэрийг тухайн онд гаргаж байх.

4.3 Аймгийн Засаг дарга С.Насанбатад зөвлөж байна.

- Худалдан авах ажиллагааг аймгийн Өмчийн газраар зохион байгуулж байх.
- Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагыг биелүүлэх, зөрчлийг давтан гаргаагүй байх талаар арга хэмжээ авч, зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны дотор ирүүлэх.

4.4 Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Батсүхэд зөвлөж байна.

- Үнэлгээний хороонд томилогдсон бүрэлдэхүүнийг бүрэн ажиллуулах.
- СС-ын 2014 оны 212 дугаар тушаалын 2.4, 4.2, 4.3, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 47 дугаар зүйлийн 47.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

